

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРААС 2021 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 05 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2021 оны 04 дүгээр сард дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 20 орны 121 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс:

Нэг удаагийн орох - 109

Хоёр удаагийн орох - 0

Олон удаагийн орох – 8

Нэг удаагийн гарах-орох - 4

Хоёр удаагийн гарах-орох – 0

Олон удаагийн гарах-орох – 0

Визийн шилжүүлэг - 0

Дамжин өнгөрөх – 0

Түр ирэгчийн бүртгэл 11, хасалт 14, оршин суух зөвшөөрлийн хасалт 29 хийсэн байна. Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон виз байхгүй.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Ковид-19 цар тахлын улмаас хяналт шалгалтын ажлыг энэ сард зохион байгуулаагүй болно.

“ISM” системээр давхардсан тоогоор 52 орны 765 гадаадын иргэний “F8” мэдээллийг шүүж шалгасан ба зөрчил илрээгүй.

1.3. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Тайлангийн хугацаанд зөрчил гаргасан гадаадын иргэн, аж ахуйн нэгж байхгүй болно.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд төвөөс 1 орны 1 гадаадын иргэн /Австрали-1/-ийг Монгол Улсаас албадан гаргах тухай байгууллагын даргын шийдвэрийг хэрэгжүүлж, уг иргэнийг албадан гаргасан талаарх тодорхойлолтыг Зөрчил шалган шийдвэрлэх газарт хүргүүлсэн.

1.5. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн АНУ-ын 1 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрлийн газарт хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 2 /үйл ажиллагаатай холбоотой 1, хүний нөөцтэй холбоотой 1/ тушаал батлан гаргаж биелэлтийг тооцсон.

Тус газрын 2021 оны 4 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталж, нийт 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүлээ:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж хүргүүлсэн, өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Захиргаа, удирдлагын газарт;

- 2022 онд тус газарт ажиллаж буй хяналтын улсын байцаагч нарт 5 жилийн урамшууллын судалгааг гаргаж Захиргаа, удирдлагын газарт, 2020 онд тус газраас ажлаас халагдсан болон чөлөөлөгдсөн албан хаагчдын судалгааг гаргаж Санхүүгийн хэлтэст тус тус хүргүүлсэн;

- Үндэсний статистикийн хороо, Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран зохион байгуулсан төрийн албан хаагчдаас үндэсний бичгийн мэдлэгийн тодорхойлох судалгааг тус газрын албан хаагчдаас авах ажлыг зохион байгуулж, тайланг Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн.

2.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Бичиг хэрэгт 3 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 2 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 4 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Энэ сард иргэн, байгууллага, албан хаагчаас өргөдөл, гомдол ирүүлээгүй болно.

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан тушаал, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан зэрэг нийт 10 баримт бичгийг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2021 оны Б/48 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 28 бөгөөд одоо ажиллаж байгаа 20 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 5 байна.

Байгууллагын даргын Б/77 дугаар тушаалаар тус газрын 2, Буянт-Ухаа дахь хэлтсийн 4 албан хаагч нарын цалингийн шатлал нэмэгдсэнийг мэдээллийн санд оруулсан.

2021 оны 04 дүгээр сарын 12-оос 23-ны өдөр хүртэл Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад тус газрын 2 албан хаагч хамрагдсан.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлөөс 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Төрийн албан дахь бодлогын инноваци-сургамж ба боломж” цахим семинарт, 04 дүгээр сарын 15-нд “Орчин үеийн техник, технологийн чиг хандлага: Виртуал орчинд ажиллах” сэдвээр, 04 дүгээр сарын 22-ны өдөр “Кибер орон зай дахь аюулгүй байдал” сэдвээр зохион байгуулагдсан цахим сургалтуудад тус газрын 1 албан хаагч хамрагдсан.

Захиргаа удирдлагын газар болон гадаад хэлний сургалтын “Дархан-Энх оршихүй” төвтэй хамтран 2021 оны 4 сарын 20-оос 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл зохион байгуулагдаж буй англи хэлний сургалтад тус газраас 10 албан хаагч хамрагдаж байна.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсөв болох 280,803,900 төгрөгийн санхүүжилт орсноос цалин хөлсөнд 169,990,066 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 45,099,043 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 12,839,717 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн 2021 оны 3 дугаар сарын тайланг гарган 2021.04.05-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 45,099,043 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн 2021 оны 3 дугаар сарын мэдээг 2021.04.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 280,803,900 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 157,248,514 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Энэ сард хүү торгууль орлого байхгүй бөгөөд визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 33,361,238 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 2,136,862 төгрөг, байрны түрээс 9,701,900 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно.

Бараа материалд 2,000,000 төгрөгийн худалдан авалтыг /Ковид-19 сэргийлэх нэг удаагийн хувцас, хэрэгсэлд/ хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох

бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд сүлжээ болон техник хэрэгслийн өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан бөгөөд нийт 10 дуудлага хүлээн авч засварлаж ажиллалаа. Дотоод сүлжээ энэ хугацаанд хэвийн ажилласан болно. Тус газрын нийт 11 компьютерийн хэвийн ажиллагааг ханган ажилласан.

Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд 2021 оны 3 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээ, 2021 оны 4 дүгээр сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчилах, танин мэдүүлэх зорилгоор биечлэн 2, утсаар 41 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Дөрөв. Бусад

Агаарын замын боомт хариуцсан газрын дарга 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр тус газрын албан хаагчдын сахилга хариуцлага, албан бэлэн байдлыг хангах ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллаж байна.

Төв аймгийн хөшгийн хөндий дэх Чингис хаан олон улсын нисэх буудлын нүүлгэн шилжүүлэх дэд ажлын хэсгийн хуралд АЗБХГ-ын дарга, хяналтын улсын ахлах байцаагч нар 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр оролцсон.

Ээлжийн ахлахууд “Чингис хаан” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчийн 10:00 цагийн шуурхай хуралд тогтмол сууж хил хяналтын бусад байгууллагуудтай мэдээлэл солилцон хамран ажилласан байна.

Захиргаа удирдлагын газарт нөхцөл байдлын мэдээг 2 удаа илтгээх хуудасаар танилцуулсан. Хоногийн мэдээг өглөө бүр 09-10 цагийн хооронд холбогдох нэгжид хүргүүлэн ажилласан.

Албан хаагчдын дархлаажуулалтыг дэмжих зорилгоор С витамин болон D витаминаар хангасан болно.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд хандаж Агаарын замын боомт хариуцсан газрын болон Буянт-Ухаа дахь хэлтсийн нийт 24 албан хаагчдад 04 дүгээр сарын 22-ны өдөр Ковид-19 эсрэг вакцины 2 дахь тунг хийлгэсэн.

Боомтод ээлжинд гарч буй албан хаагчдыг “Ковид-19” халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэг удаагийн маск, гар ариутгагч, нэг удаагийн хамгаалалтын хувцас зэргээр тухай бүр хангалт хийж ажиллаж байна.